



**“УЛААНБААТАР ЛИФТ” НӨҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/19

Улаанбаатар хот

**Лифтний засвар, техник үйлчилгээний
үнэ тарифыг шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 33 дугаар зүйлийн 33.1.2, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 110 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Лифтний угсралт, засвар шинэчлэлтийн ажлын хөдөлмөр зарцуулалтын жишиг норм” (БНБД 81-31-12), Зам тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2008 оны 53 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Лифт төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрэм”-ийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Лифтийн техник үйлчилгээ, магадлал хийлгэх үнэ тарифыг хавсралтаар баталж, 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (М.Энхбат)-т даалгасугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2016 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/06 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.ГАН-ЭРДЭНЭ

Улаанбаатар лифт НӨҮГ-ын даргын
2025 оны 08 дугаар сарын 25-ны
өдрийн А/19 дүгээр тушаалын хавсралт



Лифтэнд техник үйлчилгээ, магадлал хийх үнийн тариф

№	Үйлчилгээний төрөл	Лифтний тоо	Лифтний зогсоолын тоо	Үнэ /төгрөг/
1	Засвар, техник үйлчилгээний хөлс	1	6 хүртэл	80,000
		1	6-8 хүртэл	80,000-100,000
		1	8-12 хүртэл	100,000-120,000
		1	12-16 хүртэл	120,000-140,000
		1	17-оос дээш	140,000
2	Техникийн магадлал	1	6 хүртэл	80,000
		1	6-8 хүртэл	80,000-100,000
		1	8-12 хүртэл	100,000-120,000
		1	12-16 хүртэл	120,000-140,000
		1	17-оос дээш	140,000
3	Байгууллага, аж ахуйн нэгж	1	5-аас дээш	100,000-120,000